

“ЭРДЭНЭС СИЛВЕР РЕСУРС” ХХК-ИЙН САЛХИТЫН УУРХАЙН ХААЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ ЖИШИГ ТӨСЛИЙН МЭДЭЭ

Дугаар 4 2022 оны 1-р сар

■ ЖИШИГ ТӨСЛИЙН ЯВЦЫН ТАНИЛЦУУЛГА

Салхитын ордын хаалтын менежментийн төлөвлөгөөг боловсруулах жишиг төслийг 2021 оны 10 дугаар сараас эхлэн хэрэгжүүлж эхэлснээс хойш MERIT төслийн баг Эрх зүйн лавлах хүснэгт боловсруулах, Эрдэнэс Силвер Ресурс ТӨХК-тай хамтын ажиллагааг бэхжүүлэх, Канад улсын сайн туршлагуудын талаар мэдээлэл хүргэхээс гадна Салхитын уурхайн байгаль орчны суурь судалгааг хийж оролцогч талуудад танилцуулахад бэлэн болоод байна.


Төслийн баг 1 дүгээр сард уурхайн хаалтын менежмент газар ашиглалт ба нөхөн сэргээлтийн зорилго, зорилт боловсруулах оролцогч талуудын 3 удаагийн хэлэлцүүлэг зохион байгуулж, нөхөн сэргээлт, газар ашиглалтыг оновчтой хэрэгжүүлж буй Канад улсын туршлагыг хуваалцаж, боломжит хувилбаруудын талаар санал зөвшилцөв.

■ ХААЛТЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТУУД БОЛОВСРУУЛАХ АЧ ХОЛБОГДОЛ

Ажлын хэсгийн эхний уулзалтаар Канад улсын CPP компанийн зөвлөхүүд нөхөн сэргээлтийн зорилго, зорилт боловсруулах явц, арга зүй, шатлалыг танилцуулж, хаалтын төлөвлөлтөд газар ашиглалт, нөхөн сэргээлтийн зорилго, зорилтуудыг оновчтой тодорхойлох ач холбогдлыг тайлбарлаж, мэдээлэл хүргэлээ.

Хаалтын ерөнхий зорилго болон нарийвчилсан дэд зорилтууд нь хаалт ба нөхөн сэргээлтийн төлөвлөлт хийх үндэс болдог. Зорилго боловсруулах бүх шатанд уурхайн компани, нутгийн иргэд, бүх шатны төрийн захиргааны байгууллагууд г.м олон талын оролцоог хангаж, бүх талууд хүлээн зөвшөөрсөн зорилго төлөвлөлт чухал юм.

Уурхай эзэмшигч Эрдэнэс Силвер Ресурс ТӨХК нь оролцогч талуудын хэрэгцээ шаардлагыг харгалзан үзсэний дүнд газар ашиглалт, нөхөн сэргээлтийн зорилгыг баталгаажуулж, эцсийн шийдвэр гаргана. Харин хаалтын менежментийн төлөвлөгөөг Монгол улсын хууль тогтоомж, дүрэм журамд нийцүүлэн боловсруулсан эсэхийг холбогдох төрийн захиргааны байгууллагууд хянаж, батална. Компанийн зүгээс оролцогч талуудын санал зөвлөмжийг хаалтын төлөвлөлтөд хэрхэн тусгасан талаар тайлагнах болно.



Хаалтын менежментийн зорилго олон талын ач холбогдолтой. Үүнд:

- Нөхөн сэргээлтийн дараах үр дүнг төлөвлөх
- Уурхайн компанийн нэр хүндийг илэрхийлэх
- Уурхайн дараах эцсийн газар ашиглалтын зориулалтыг тодорхойлох
- Орон нутгийн нийгэм-эдийн засгийн хөгжлийн хөтөлбөрүүдтэй уялдуулах
- Оролцогч талууд болон олон нийтийн оролцоо, саналыг тусгах

Хаалтын зорилго, зорилтыг боловсруулахад тухайн дэвшүүлсэн зорилго нь хууль тогтоомжийн шаардлагуудад нийцсэн, компанийн санхүүгийн болон үйл ажиллагааны нөөц боломжийг түшиглэсэн, түүнчлэн орон нутгийн болон хөгжлийн бодлого төлөвлөлтүүдтэй уялдсан байх нь чухал. Хаалтын зорилго, зорилт боловсруулахад харгалзан үзэх шаардлагатай дотоод болон гадаад хүчин зүйлсийг дээрх зургаар харуулав.

■ ЭРДЭНЭС СИЛВЕР РЕСУРС ТӨХК-ИЙН ТАНИЛЦУУЛГА БА ХААЛТЫН ТӨЛӨВЛӨЛТ

Ажлын хэсгийн 2 дугаар уулзалтын үеэр Эрдэнэс Силвер Ресурс компани нь нөхөн сэргээлтийн төлөвлөлтийн талаар оролцогч талуудад мэдээлэл хүргэв.

Монгол Улсын стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордууд дахь төрийн төлөөллийг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй “Эрдэнэс Монгол” ХХК-ийн охин компани, “Эрдэнэс Силвер ресурс” ТӨХК нь анх 2019 оны 5 дугаар сард үүсгэн байгуулагдсан.

2019 оны 6 дугаар сард Дундговь аймгийн Гурвансайхан сумын нутагт орших Салхитын алт мөнгөний ордыг олборлох ашиглалтын тусгай зөвшөөрөл олгожээ. 2020 оны 1 дүгээр сард Монгол улсын Засгийн газраас тус ордыг эдийн засгийн эргэлтэд оруулсан орлогоос иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн тодорхой хэсгийг төлөхөөр шийдвэрлэж, 230 орчим мянган тэтгэврийн зээлтэй иргэдийн зээлийн төлбөрийг тэглэсэн. Түүнээс хойш лицензийн талбайд нэмэлт хайгуулын ажил хийж нөөцийг нэмэгдүүлэх, баяжуулах үйлдвэрийг сэргээн засварлах зэргээр бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг 6 сараас эхлэн жигдрүүлэх, өөрийн хөрөнгөөр үйл ажиллагаагаа санхүүжүүлэх талаар анхаарч ажиллаж буй ажээ. БНХАУ болон Европын улсууд уруу баяжмал борлуулах гэрээ хийж, экспортолж эхэлсэн байна. Түүнчлэн “Эрдэнэс Силвер ресурс” ТӨХК цаашид техник-эдийн засгийг судалгааг шинэчилж, үйлдвэрлэлийн хүчин чадлаа нэмэгдүүлэхээр зорьж буй юм байна.

Дараах зургуудаар Салхитын ордын ил ухаш, хаягдлын сан, хаягдал овоолго болон хүдэр баяжуулах үйлдвэрийг харуулав.



Салхитын уурхайн ил уурхай ба хаягдал овоолго



Салхитын ил уурхайн хаягдлын сан



Салхитын ил уурхайн хүдэр баяжуулах үйлдвэр

Салхит уурхайн өнөөгийн байдал, тоо баримтаар:

- Уурхайн гүн - 70 м
- Уурхайн хэмжээ -30 га
- Хөрсний овоолгын талбайн хэмжээ -28 га
- Хөрсний овоолгын эзлэхүүн - 6.3 сая м3
- Баяжуулах үйлдвэрийн талбай-18 га
- Хаягдлын сангийн эзлэхүүн - 550 мян.м3
- Хаягдлын сангийн талбай - 11 га

“Салхит” мөнгө-алтны үндсэн ордыг ил аргаар ашиглах төслийн хувьд уурхайн ухаш, хаягдал овоолго, хаягдлын сан гэх мэт уурхайн байгууламжийг холбогдох хууль, журам, стандартын дагуу нөхөн сэргээх, мөн барилга байгууламжийг татан буулгах ерөнхий төлөвлөлт баримталж байна. Компани хаалтын менежментийг дараах үе шаттай хэрэгжүүлэхээр төлөвлөж буй ажээ. Үүнд: I) Баяжуулах үйлдвэр, барилга байгууламжийг буулгаж зөөх, эсвэл оролцогч талуудтай зөвшилцөж тодорхой зориулалтаар ашиглахаар үлдээх, II) Олборлолт явуулсан талбайд техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх, III) Нөхөн сэргээлтийн дараах хяналт, мониторинг хийх, IV) Хаалт, нөхөн сэргээлтийн гүйцэтгэлийг дуусгаж, тайлагнах, V) Уурхайн эдэлбэр газрыг орон нутагт хүлээлгэн өгөх, газар чөлөөлөх

■ ХААЛТЫН ДАРААХ ГАЗАР АШИГЛАЛТЫГ ТОДОРХОЙЛОХ

Олон улсын уул уурхай ба металлургийн зөвлөлөөс эрхлэн гаргасан “Уурхайн хаалтын тэргүүн туршлага” гарын авлагад дараах 9 хүчин зүйлсийг харгалзан хаалтын дараах газар ашиглалтын зориулалтыг тодорхойлно хэмээжээ. Иймд Салхитын уурхайн хаалтын төлөвлөлт хийхэд эдгээр хүчин зүйлшиг зайлшгүй харгалзан үзэх ёстой. Үүнд:

- Уурхайн байршил
- Эвдрэлд өртөхийн өмнөх буюу ойролцоох газар ашиглалтын зориулалт
- Уурхайн олборлолтоос газрын гадаргууг хувиргасан үндсэн өөрчлөлтүүд
- Газрын чадамж (газар ашиглалтын боломжийг тодорхойлно)
- Хууль, эрх зүйн шаардлагууд
- Нийгэм эдийн засгийн нөхцөл байдал, үүнд: нутгийн иргэд г.м гол оролцогч талуудын хэрэгцээ шаардлага
- Газар эзэмшил
- Эдийн засгийн үр өгөөж
- Бүс нутгийн төлөвлөлт


■ САЛХИТЫН ОРДЫН ХААЛТЫН ЗОРИЛГО ТОДОРХОЙЛОХ ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Ажлын хэсгийн 2 дах хэлэлцүүлгийн үеэр оролцогч талууд Салхитын ордын хаалтын дараах газар ашиглалтын зориулалтыг тодорхойлох талаар санал солилцож, зөвшилцөв. Эрдэнэс Силвер Ресурс ТӨХК, УУХҮЯ, БОАЖЯ, АМГТГ, Усны агентлаг, Дундговь аймгийн ЗДТГ, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Мэргэжлийн хяналтын газар болон Гурвансайхан сум зэрэг холбогдох байгууллагуудын төлөөлөл нийт 30 гаруй оролцогчид санал бодлоо хуваалцав.

СРР энвайронментал Канад зөвлөхүүд 2 дах хэлэлцүүлгээс оролцогч талууд санал болгосон нөхөн сэргээлт, газар ашиглалтын хувилбаруудыг нэгтгэн, 8 чиглэлийн 11 зорилго болгон багцалж танилцууллаа. Оролцогчид хаалтын дараах газар ашиглалтын хэлбэрийг хөдөө аж ахуй, аялал жуулчлал, хөнгөн үйлдвэр, сургалт-судалгааны төв, экологи-байгаль хамгаалал, амралт сувилал, зам тээвэр ба усан хангамж зэрэг чиглэлүүдээр ашиглах боломжтой гэж тус тус тодорхойлов. 3 дах удаагийн хэлэлцүүлгээр оролцогч талууд хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр ба экологи, байгаль хамгааллын чиглэлүүдээр газар ашиглах хувилбаруудад илүү ач холбогдол өгч, нарийвчлан хэлэлцэв.

MERIT төслийн зүгээс өмнө тодорхойлсон нөхөн сэргээлтийн зорилго, газар ашиглалтын боломжит хувилбаруудыг эрэмбэлэх

цахим судалгааг зохион байгуулж, дүнг нэгтгэн оролцогч талуудын дараагийн уулзалтаар танилцуулах болно. Ажлын хэсгийн гишүүд судалгааны дүнг үндэслэн нөхөн сэргээлтийн зорилгыг эцэслэн тодорхойлж, зөвлөмж болгох юм.



Оролцогч талуудын ажлын хэсгийн уулзалт №01: Нөхөн сэргээлтийн зорилго, зорилтууд тодорхойлох